

мэргэшүүлэх багц сургалтыг Дотоод хэргийн их сургууль хариуцан зохион байгуулах боломжтой.

Дээрх бүхнээс үндэслэн дараах дүгнэлт, саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1 .Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтныг үе шаттай сургах сургалтын тогтолцоо хараахан үгүй байна.

2 . Нийт удирдах ажилтнуудаас удирдахуйн ухааны боловсрол эзэмшсэн алба хаагчдын эзлэх жин бага байна.

3 .Удирдах ажилтны сургалт-зөвлөгөөний чанар, үр дүнг нэмэгдүүлэх шаардлага байна.

4 .Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн төгсөгчдөөс удирдах ажилтны хүний нөөцийг бүрдүүлж байх,

б .Удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнд сургалтын цагийн нэмэгдүүлэх,

б .Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академиас Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудад “Удирдах ажилтны сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгаа”-г хийж хүргүүлсэн. Уг судалгаанд суурилсан мэргэшүүлэх багц сургалтыг хэрэгжүүлэх,

7 .Дээрх судалгаанд суурилсан Удирдлагын академийн зохион байгуулж буй “Албан тушаалын дамжаа”, “Стратегийн дамжаа” зэрэг богино хугацааны сургалтыг шат шатны мэргэшүүлэх багц сургалт болгох,

8 .Чадахуйн зарчимд суурилсан мэргэшүүлэх багц сургалтыг хэрэгжүүлэх хүрээнд Удирдлагын академиас суралцагч бүрт “Албан хаагчийн удирдах чадавхи эзэмшсэн байдал”-ын тодорхойлолт гаргах бөгөөд уг тодорхойлолтыг харгалзан төгсөгчийг албан тушаалд томилох тогтолцоог бий болгох зэрэг саналыг танилцуулж байна.

УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ХИЛИЙН АЛБАНЫ СУРГАЛТЫН ӨНЦЛОГ, АРГА, ХЭЛБЭР

*Я.Ариунболд-Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын
академийн Хилийн алоаны удирдлага, стратегийн
профессорын багийн профессор, хурандаа*

Оршил

Сургалт нь удирдлагын тогтолцоотой холбоотой бөгөөд удирдлага нь Улс төрийн, Захиргааны, Мэргэжлийн удирдлагад хамаарч төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд нь өөр өөрийн хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн сургалтыг зохион байгуулдаг.

Мэргэжлийн сургалтыг, мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 4.1.4-т “мэргэжлийн сургалт” гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагаа хэмээн томъёолжээ.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 34.1 дүгээр заалтад улсын хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байх бөгөөд хилийн цэрэг нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хилийн цэргийн штаб,

анги, салбар, зэвсэглэл, техник, ар тал, хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна гэж хуульчилсан байна.

Иймээс хилийн албаны сургалтын уламжлал нь цэргийн сургалтад тулгуурлагддаг бөгөөд цэргийн сургалт гэдэг нь офицер цэрэг хоёрын сурах, сургах гэсэн олон талт үйл ажиллагааны нэгдэл гол зорилго нь цэргийн хэргийн тодорхой хэмжээний мэдлэг, дадлага чадварыг эзэмшүүлэхэд оршдог.

Хилийн алба гэдгийг: Монгол Улсын хилчний тайлбар тольд¹

1. Монгол Улсын хил хамгаалалтын нэг төрөл.

2. Монгол Улсын хилийн тодорхой хэсгийг /зорилт, газар орон, цаг хугацаагаар/ тасралтгүй хамгаалахад чиглэгдсэн хилийн анги, салбаруудын үйл ажиллагааны үндсэн хэлбэр.

3. Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах зорилгоор цэргийн болон тагнуул, инженерийн арга хэмжээтэй хослуулан хилийн анги, салбаруудаас зорилго, үүрэг, чиглэл, газар орон, цаг хугацааг тохируулан тасралтгүй явуулж байгаа үйл ажиллагаа.

Агуулга нь: Хилийн тусгай анги, салбаруудаас хил манах зорилтоо биелүүлэхэд бэлтгэх, түүнийг гүйцэтгэхээр цэргийн болон тагнуулын ажиллагааг зохион байгуулж явуулах, хилийн дэглэм, хил орчмын дэглэм /хилийн бүс, зурвас, хилийн боомт газарт тогтоосон журам/ -ийн биелэлтэд хяналт тавих зэрэг ажиллагаанаас бүрдэнэ.

4. Тайван цагт улсын хил манах, хилийн болон хил орчмын дэглэм сахиулахын тулд орон тооны хүч хэрэгсэл, иргэд, хил хамгаалахад туслах хүчний идэвхтэй оролцоотой нутгийн засаг захиргааны нэгж, цагдаа, тагнуулын байгууллагатай нягт харилцан ажиллаж хэрэгжүүлдэг цэргийн болон инженер- техник, тагнуул, захиргаа, хууль хяналтын цогц үйл ажиллагаа гэж тайлбарласан бол “Хилийн нэр томъёоны тайлбар толь”-д 1. Улсын хил хамгаалах зориулалт бүхий хилийн анги, салбар байгууллагад Монгол улсын иргэд алба хаах төрийн албаны онцгой төрөл.

2. Улсын хил хамгаалах алба-байлдааны ажиллагааны хэлбэр бөгөөд улсын хилийн зөрчил болон Монгол улсын хил хязгаарын орон зайд хуулиар тогтоосон эрх зүйн бусад дэглэмд халдсан халдлагыг илрүүлэх, таслан зогсоход чиглэгдсэн ХХБ-аас үүрэг, зорилго, орон зай, цаг хугацаагаар нь зохицуулан тасралтгүй явуулж буй оперативын, дэглэмийн, хяналт шалгалтын болон бусад арга хэмжээ гэж тус тус тайлбарласан байна.

Дээрх тайлбаруудаас хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах үндсэн арга нь хилийн алба гэж ойлгож болохоор байна.

Хилийн албаны сургалт нь улсын хил хамгаалах алба-байлдааны ажиллагаанд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, дадлагыг эзэмшүүлж, хилийн анги салбаруудыг бие даан болон харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтран хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдан явуулах арга ажиллагаанд сургах үндсэн сургалт юм.

Үндсэн хэсэг

1. Хилийн албаны сургалтын онцлог

Хилийн албаны сургалт нь суралцагч албан тушаалтан бүрд тохирсон агуулгатай, төлөвлөлтийн тодорхой зохион байгуулалт, сургалтын хэлбэр, арга ажиллагаа, хэрэгсэл, тактикийн бэлтгэл сургалтын төвшинг илэрхийлсэн тоон болон чанарын үзүүлэлт, нормативыг өөртөө багтааж бие бүрэлдэхүүнд үүссэн цагийн байдалд үүрэг гүйцэтгэх үр чадвар олгоход чиглэгдсэн олон төрлийн хичээл,

¹ Монгол Улсын хилчний тайлбар толь. УБ. 2003 он. 246 дахь тал

хээрийн сургуулийг багтаасан зохион байгуулалттай, төлөвлөгөөт үйл ажиллагаа бөгөөд хилчдийн алба хаах бүхий л хугацаанд хилийн албаны сургалт тасралтгүй явагдана.

Хилийн албаны сургалтыг цэргийн болон хил судлалын шинжлэх ухааны онолд суурилж, хил хамгаалах урлагийн хүрээнд тактик, оператив, стратегийн түвшинд зохион байгуулж явуулдаг.

Хилийн албаны хичээлүүд нь өөрийн судлах зүйл, заах аргаар өөр өөр байх боловч, эцсийн зорилго нь хил хамгаалалтыг бэлтгэж, явуулах ажиллагаанд сургаж, улсын хилийг найдвартай хамгаалахад чиглэгдэнэ.

Хилчид тайван цагт байлдааны үүрэг гүйцэтгэж байдаг онцлогт тохируулан хилчдийг сургахад хилийн албаны хичээл гол үүрэг гүйцэтгэнэ.

Хилийн алба нь улсын хил хамгаалах үүргийг биелүүлэхэд хилийн манаа, харуул, застав, отрядын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдан явуулах, хил дамнасан гэмт хэрэг, хууль бусаар хилээр эд зүйл нэвтрүүлэх, зөрчигчтэй тэмцэх, олон улсын гэрээ, хэлэлцээрийг сахиулах, шалган нэвтрүүлэх арга ажиллагаанд сургадаг цэргийн тусгай бэлтгэлийн нэг юм.

Хилийн албаны сургалтыг зөвхөн хууль тогтоомж дүрэм, зааврыг танилцуулж, болсон үйл явдлыг мэдээлснээр хязгаарлан, онол арга зүйн үндэслэл муутай явуулбал тавьсан зорилгоо хангахгүй.

Хилийн албаны хичээл нь өөрийн гэсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, цэргийн сургалтын зарчим, заах арга, хэлбэрүүдээр явагддаг.

Хилийн албаны хичээл заах багш нь хичээл заах арга зүйгээс гадна албаны болон цэргийн сургалтын ерөнхий онолыг зайлшгүй судалсан, албан үүрэг гүйцэтгэх үед үүсч болох тодорхой цагийн байдалд ажиллах туршлагатай байж хилийн албаны мэдлэг, дадлага чадварыг олгоно.

Хилийн албаны мэдлэг нь олон улсын гэрээ хэлэлцээр болон Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичиг. хилийн албаны дүрэм, заавар, удирдлагын тушаал шийдвэр, улсын хил хамгаалалтын мөн чанар. зорчигч тээврийн хэрэгслийг хилээр шалган нэвтрүүлэх, хууль бусаар хилээр эд зүйл нэвтрүүлэх, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх. хилийн тусгай дэглэм. журам. манааны албан үүрэг гүйцэтгэх, хил зөрчигчийг эрж саатуулах, онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах зэрэг мэргэжлийн ур чадвараар илэрхийлэгдэнэ.

Хилийн албаны сургалт нь хүн нэг бүрийн бэлтгэл. салаа салбарын бэлтгэл, удирдлагын бэлтгэл гэж ангилагдан цэргийн сургалтын үндсэн зарчмуудад тулгуурлан явагддаг.

Цэргийн сургалтын үндсэн зарчмууд:

- Сургалт шинжлэх ухааны үндэслэлтэй байх;
- Эсрэгталаа ялан дийлэхэд хэрэгтэй бүхэнд сургахд
- Сургалтыг байлдааны бэлэн байдлыг хангахад чиглүүлэх;
- Дайчдыг ухамсарлуулан идэвхжүүлэх;
- Үзүүлж, таниулах;
- Сургалт систем дэс дараалалтай явагдах;
- Мэдлэг, дадлага, чадварыг эзэмшүүлэх;
- Хялбар дөхөм байх;
- Бүлгээр болон ганцаарчлан ажиллаж сургах зэрэг зарчмууд

багтана.

Цэргийн сургалтын 25 хувь нь онол, 75 хувь нь дадлага байдаг.

Сургалтын зарчим нь сургалтын процессын удирдамжийг тодорхойлдог бол үйл ажиллагааны дүрэм, заавар журам нь тусгай нэгж, салбар юу хийхийг тусгасан байдаг.

Хилийн албаны сургалтыг сургалтын зарчмуудад тулгуурлан тусгай арга, хэлбэрээр явуулдаг. Сургалтын зарчим арга, хэлбэрүүд нь хоорондоо нягт холбоотой, нэг нь нөгөөгөө баяжуулж байдаг.

Хилийн сургуулийн 2,3,4-р дамжааны сонсогчдоос

1. Хилийн албаны талаарх таны ойлголт?

2. Хилийн алба нь ямар салбар шинжлэх ухаанд багтах вэ?

3. Хилийн албаны хичээл ямар сургалтын аргаар явагдаж байна вэ?

Гэсэн асуулт бүхий судалгааг авахад

1. Хилийн албан талаарх таны ойлголт гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 35 сонсогчийн 32 нь буюу 91,4 хувь нь сайн хариулсан байна.

2. Хилийн алба нь ямар салбар шинжлэх ухаанд багтах вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 35 сонсогчийн 16 нь буюу 45 хувь нь цэргийн шинжлэх ухаан, 19 нь буюу 55 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

3. Хилийн албаны хичээл ямар сургалтын ямар хэлбэр, аргаар явагдаж байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 35 сонсогчийн 31 нь буюу 88,5 хувь нь лекц, семинар, дадлага, хээрийн гаралт гэсэн хариулт өгсөн байна.

Судалгаанаас харахад хилийн албаны сургалтыг багш нар үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг судлуулж, хил хамгаалалтын дүрэм, заавар, журмыг удирдлага болгон лекц, семинар, дасгал үйлдүүлэн хээрийн гаралтаар тактик ажиллагаанд сургах байдлаар явуулж байна,

Хилийн сургуулийн хилийн албаны сургалтын дараагийн шатны үргэжлэл нь Удирдлагын академийн хилийн стратеги тактикийн сургалт бөгөөд сургалт шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчмын дагуу хилийн албаны суурь шинжлэх ухааны талаар гүнзгийрүүлсэн хичээлийн хөтөлбөрийн цаг сэдвийн задланд тусган тодорхой ойлголт өгч онол практикийн нэгдлийг туршлага болгон цэргийн сургалтын удирдах бүрэлдэхүүний үндсэн зарчим, арга, хэлбэрийг эзэмшүүлж байгаагаар онцлогтой.

Удирдлагын академи төгсөөд хилийн анги салбарт болон харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтарсан шат шатны сургалт, хээрийн сургуулиудыг зохион байгуулах офицерууд цэргийн сургалтын зарчим, арга, хэлбэрийн талаар тодорхой мэдлэгтэй, нэгдсэн болон хэсэгчилсэн дадлага, команд штабын сургууль зохион байгуулах чадвартай байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хоёр: Цэргийн сургалтын хэлбэр, арга

Цэргийн сургалтын хэлбэр

Хэлбэр гэдэг үг нь бүтэц гэсэн утга бүхий латин үгнээс гаралтай. Сургалтын хэлбэр нь сурах үйл явцыг хэрэгжүүлж суралцагсад системтэй ур чадвар олгох шат дараалсан ажилбарууд юм.

Хилийн албаны сургалт нь хил хамгаалалтын зохион байгуулалтын талыг харуулсан сургалтын ба албаны үйл ажиллагааны тодорхой хэлбэрээр явагдана.

Суралцагсдын ТОО ХЭМЖЭЭ, ХИЧЭЭЛЛЭХ хугацаа, газар, журам, сурагч сургагчийн хоорондын холбоо, нэг бүрийн болон салаа салбарын гүйцэтгэх үүргээс шалтгаалан тухайн сургалтын хэлбэр тодорхойлогдоно.

Цэргийн сургалтын хэлбэрүүдэл: Лекц, семинар, Бие даалт, Бүлгийн дасгал, Шуурхай дадлага, Тактик-жагсаалын хичээл, Тактикийн хичээл, Хээрийн нэгдсэн хичээл, Сурган зааварлах хичээл, Штабын хэсэгчилсэн дадлага, Штабын нэгдсэн дадлага, Команд штабын цэргийн тоглоом, Команд штабын сургууль, Команд штабын хээрийн сургууль, Тактикийн хээрийн сургууль, Байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль зэрэг хэлбэрүүдээр цэргийн сургалт явагддаг.

Эдгээр хэлбэрүүдийн бүтэц нь өөр өөр байх ба ямар аргаар яаж явуулахыг ойлгохгүйгээр хилийн албаны сургалтыг явуулахад хүдрэлтэй юм.

Эдгээр хэлбэрүүдийг нэг бүрчлэн тайлбарлах боломжгүй бөгөөд зайлшгүй хилийн албанд хэрэглэгддэг онол, дадлага, дасгал, бие даалт, практик ажиллагаа буюу хээрийн хичээл, тактик-жагсаалын хэлбэрийг товч авч үзье.

Хилийн албаны хичээл заах арга зүй 1,2 /Ч.Дашдэлэг 1986 он/, Офицер, штаб, нэгтгэл, ангид тактикийн бэлтгэл заах арга зүй /1974он/ зэрэг номонд дэлгэрэнгүй тусгасан байдаг.

Эдгээр хэлбэрүүд нь цэргийн сургалтын хялбар дөхөм байх зарчмын дагуу хөнгөнөөс хүндрүү чиглэсэн өөр хоорондоо нягт холбоотой, нэг нь нөгөөгөө баяжуулж байдаг.

Хилийн албаны тактикийн бэлтгэлийн сургалтын процессын өөр нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь дайчдад хилийн албаны дадлага чадвар суулгах явдал юм.

Хилийн албаны хичээл нь сургалтын зорилго агуулгаас шалтгаалж зөвхөн ангид төдийгүй төрөл бүрийн газар орон, цагийн байдлын хүндэрсэн нөхцөлд хээр явагдах бөгөөд түүнийг зохион байгуулалтын талаас:

- Онол
- Дадлага
- Дасгал
- Бие даалт
- Практик ажиллагаа буюу хээрийн хичээл гэсэн үндсэн хэлбэрүүдэд

хуваана.

Онолын хичээл: Хилийн албаны онолын хичээлээр орчин үеийн улсын хил хамгаалалт, арга тактикийн онолын үндсүүдийг судална. Онолын хичээл нь гол төлөв танхимд явагдана.

Онолын хичээл нь зохион байгуулалтын хэсэг шинэ мэдлэг олгох хэсэг, сонсогчдод олсон мэдлэгийг бататгах хэсэг, дүгнэх, даалгавар өгөх хэсэг гэсэн бүтэцтэй байна.

Дадлагын хичээл нь: тактик-жагсаалын ба тактикийн хичээл, зэвсэг техник дээр хийгдэх дадлагын хичээлийн хэлбэрүүдээр явагдана.

Дадлагын хичээл нь зохион байгуулалтын хэсэг, мэдлэг шалгах хэсэг, хийж гүйцэтгэх ажлыг үзүүлж тайлбарлах хэсэг, дайчдаар бие даалган дадлага сургууль хийлгэх хэсэг, дүгнэж даалгавар өгөх хэсэг гэсэн бүтэцтэй байна.

Дасгалын хичээл нь сургуульд оролцогсдыг чадвар дадлагатай болгож, түүнийг улам боловсронгуй болгох зорилгоор ямар нэг үйлдэл, арга барилыг олон давтан үйлдэнэ.

Дасгал, дадлага хоёр бол нэг аргын хоёр тал юм.

Дадлагаар олж авсан чадварыг улам боловсронгуй болгох зорилгоор хүндрүүлсэн цагийн байдал дээр дасгалыг явуулдаг.

Дасгал (дадлага)-ын арга нь тактикийн бэлтгэлийн явцад тактик-жагсаалын сургууль, тактикийн шуурхай дадлага болон бүлгийн дасгал хийхэд өргөн хэрэглэгдэнэ.

Хилийн албаны тактик-жагсаалын хичээл нь албаны бэлтгэлийг заах хичээлийн үндсэн хэлбэр, хилийн манааны албаны талаар анхны мэдэгдэхүүн олгох болох гэж байгаа хээрийн сургууль, тактикийн хичээлийн гол чухал асуудлыг боловсруулах, өмнөх хичээлүүдэд заагдсан алдаа дутагдлыг засах, хилийн манааны тактик үйл ажиллагааны үйлдлийг элемент элементээр үзүүлж дасгал хийлгэдэг.

Хилийн албаны тактик-жагсаалын хичээлийн онцлог нь хичээлээр боловсруулж байгаа асуудлын үйлдлийг элемент элементээр үзүүлж, дасгал хийлгэн нормативт хугацаанд багттал нэг бүрчлэн давтуулж элементийг зөв хийдэг болгосны дараа асуудлыг эхнээс нь дуустал бүхэлд нь бие даалган хийлгэдэг. Тактик-жагсаалын хичээлийг заах үндсэн арга нь дасгал, дадлага байна.

Тактик жагсаалын хичээл нь зохион байгуулалтын хэсэг, мэдлэг шалгах хэсэг, хичээлийн зорилтыг танилцуулж, манааны үлгэр жишээ ажиллагааг үзүүлэх хэсэг, түүний дагуу дайчдыг бие даалган сургуулилах хэсэг, дүгнэж даалгавар өгөх хэсэг гэсэн бүтэцтэй байна.

Бие даалтын хичээл нь сургалтад голлох үүрэг гүйцэтгэнэ. Бие даан эх сурвалж, хичээлийн холбогдолтой материал судлах нь сонсогчдоос бие даан асуудлыг боловсруулах чөлөөтэй сэтгэдэг, дүгнэдэг, мэдэж байгаа зүйлээ нэвтрүүлж чаддаг дадлагыг олж авдаг.

Бие даалтын хичээл нь зохион байгуулалтын хэсэг мэдлэгийг бататган давтах чиглэлээр даалгаврыг шалгах хэсэг, даалгавар өгөх хэсэг, хичээлийн төгсгөл гэсэн бүтэцтэй байна.

Практик ажиллагааны хичээл нь: Сонсогчдоос, байлдааны цагийн байдалд ойртсон тийм нөхцөлд, тодорхой хугацаанд өөрийн үүрэгт ажлаа хийж гүйцэтгэхийг хэлнэ.

Практик ажиллагаа нь сонсогчдоос тодорхой хэмжээний бэлтгэл, бие даан ажиллах өндөр чадварыг шаарддаг тул суралцагчдаас дадлагын зохих хэмжээний мэдлэг чадвар эзэмшсэний дараа энэ ажилд шилжин орно.

Практик хээрийн ажиллагааны сургалт нь сонсогчдоос өмнөх сургалтын явцад олж авсан мэдлэг, чадвар, дадлага нь зайлшгүй хэрэгцээтэй зүйл болохыг зөвшөөрч өөрийн бэлтгэлийн төвшинг шалгах бололцоог олгодог.

Мэдлэг: Бодит байдлыг танин мэдсэн, практикаар шалгарсан үр дүн, тэр нь хүний сэтгэхүйд буусан зөв тусгал. Ердийн болон шинжлэх ухааны гэж ангилна.

Дадлага: Хувь хүн аливаа үйлдлийг ухамсарлаж ойлгосны үндсэн дээр зөв хийж сурахыг дадлага гэнэ. Тодорхой хэмжээний дадлага хийхгүйгээр чадвар эзэмшиж чадахгүй.

Чадвар: Аливаа үйлдлийг ухамсартай, бүтээлч, тооцоотой, түргэн шуурхай хийж чаддаг болтлоо эзэмшихийг чадвар гэнэ. Чадвар нь онол, практикийн мэдлэгт түшиглэсэн үйл ажиллагаа бөгөөд харин дадлага нь зөвхөн түүний эхний шат болно.

Цэргийн сургалтын арга

Арга бол зорилгод хүрэх зам мөн. Өөрөөр хэлбэл тавьсан зорилгодоо хүрэхийн тулд ашигладаг арга барил, үйлдлүүдийн цогцолбор юм.

Хичээлийнхээ агуулгыг суралцагчдад эзэмшүүлэхийн тулд байшийн хэрэглэж байгаа сургалтын аргаас сургалтын чанар ихээхэн шалтгаална.

Суралцагчдад хилийн албаны тухай тодорхой мэдлэг, дадлага, чадвар эзэмшүүлэх, жигдрэлтийг хангахад

1. Шинэ мэдлэг олгох, олсон мэдлэгийг бэхжүүлэх
2. Дадлага чадвар суулгах
3. Тактикийн сэтгэлгээг хөгжүүлэх гэсэн үндсэн зорилго тавигдана.

Хилийн албаны мэдлэг, дадлага, чадвар эзэмшүүлэх, жигдрэлтийг хангах сургалтыг тухайн багш ярих, тайлбарлах, ярилцах, үзүүлэх, дасгах, бие даалгах, асуух, шалгах, үйлдүүлэх, зуруулах, бичүүлэх, дасгал хийлгэх, бүлэглэх болон ганцаарчлан заах гэх мэт аргыг ашиглана.

Дүгнэлт

Удирдлагын академийн Хилийн албаны сургалтыг суралцагч нарт тохирсон агуулгатай, төлөвлөлтийн тодорхой зохион байгуулалт, сургалтын хэлбэр, арга ажиллагаа, хэрэгсэл, тактикийн бэлтгэл сургалтын түвшинд онолоос илүүтэй дадлага, дасгал, чадвар олгоход чиглэгдсэн байдлаар явуулах нь үр дүнтэй бөгөөд цэргийн болон хил судлалын шинжлэх ухааны онолын суурь ойлголтыг өгч хил хамгаалах урлагийн тактик, оператив, стратегийн түвшинд хил хамгаалалтыг бэлтгэж, явуулах ажиллагаанд сургаж, улсын хилийг найдвартай хамгаалахад хэрэгцээтэй бүхэнд сургахад албаны сургалтыг хандуулах нь зүйтэй.

Хилчид тайван цагт байлдааны үүрэг гүйцэтгэж байдаг албаны онцлогт тохируулан хилчдийг сургахад хилийн албаны хичээл гол үүрэг гүйцэтгэнэ.

Хилийн алба нь улсын хил хамгаалах үүргийг биелүүлэхэд хилийн манаа, харуул, застав, отрядын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдан явуулах, хил зөрчигчтэй тэмцэх арга ажиллагаанд сургахдаа зөвхөн хууль тогтоомж дүрэм, зааврын хүрээнд кейс жишээ болсон үйл явдалд дүгнэлт хийн бодлого бодуулах уламжлалт хил хамгаалалт, хилийн манааны ажиллагааг эзэмшүүлэхээс гадна өнөөдөр дэлхийн бусад улс оронд хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилийн манааны арга тактик, өрнөж буй цагийн байдал, ашиглагдаж буй техник хэрэгслийг талаар тодорхой ойлголт өгч мэдлэг, дадлага, чадварыг хөгжүүлэх ирээдүйд үүсч болох цагийн байдалд ажиллахад бэлтгэгдсэн офицеруудыг бэлдэх нь өнөөгийн эрэлт байж болох юм.

Сургалтын зарчим нь сургалтын процессын удирдамжийг тодорхойлдог бол үйл ажиллагааны дүрэм, заавар журам нь тусгай нэгж. салбар юу хийхийг тусгасан байдаг.

Хилийн албаны сургалтыг хилийн албаны мэдлэг, дадлага, туршлага мөн сургалтын аргаар хослуулан явуулах бөгөөд цэргийн сургалтын зарчим, хэлбэр, арга зүйг эзэмших, суралцагч нарт эзэмшүүлэх нь зүйтэй гэж дүгнэж болохоор байна.

Дараагийн дугаараар цэргийн сургалтын бусад хэлбэр аргын талаар ялангуяа удирдах бүрэлдэхүүнтэй явагддаг бүлгийн дасгал, штабын нэгдсэн болон хэсэгчилсэн дадлага, команд штабын сургуулийн талаарх мэдээллийг та бүхэнтэйгээ хуваалцах болно.